



Аймгийн ИТХ-ийн ээлжит IV хуралдаан энэ сарын 3-ны одор хуралдаж, ИТХ-ын 2013 оны тайлан, цаашдын зорилтын тухай, аймгийн Засаг даргын вйл ажиллагааны хотолборийн 2013 оны хэрэгжилт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх тухай, аймгийн тосвийн 2013 оны хвлээгдэж буй гүйцэтгэл, 2014 оны тосол, 2012 оны гүйцэтгэлийн тухай мон аймгийн Аудитын газрын 2013 оны ажлын тайлан, орон нутгийн 2014 оны Тосвийн тосол болон тосвийн

хоронгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар огох саналын тухай, Говийн Их дархан газрын Б хэсгийн орготголийг дэмжих тухай илтгэлүүдийг хэлэлцэв.

Эдгээрээс толоологчид болон оролцогчдын анхаарлын товд байсан нь тосвийн асуудал болон аймгийн Засаг даргын вйл ажиллагааны хотолборийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд гэж болно.

Тосвийн хувьд эдийн засгийн нохцол байдал улсын хэмжээнд хвндэрсэн, ард иргэдийн амжиргааны ортог нэмэгдэж, хэрэглээний внийн индекс харьцангуй оссон, 2013 оны

хвлээгдэж буй тосвийн гүйцэтгэлд тодотгол хийгдэж, тосвийн орлого зарлагын биелэлтэнд эргэлзээтэй нохцол байдал үүссэн ийм үед ирэх оны тосвийн тослийг хэлэлцэж буйгаараа онцлогтой байв.



Хуралдаанаар аймгийн 2014 оны тосвийн нийт орлого тусламжийн дvнг 63546107,8 тогрог, vүнээс тосвийн орлогыг 7751323,9 тогрог, урсгал орлогыг 7539762,5 тогрог, татварын орлогыг 6984912,5 тогрог, хоронгийн орлогыг 100000,0 тогрог, тусламжын орлогыг 55794783,9 тогрог, Засаг даргын Тамгын газрын харьяа тосовт байгууллагуудын тосовт товлорvүлэх орлогыг 7746323,9 тогрог, аймгийн 2014 оны тосвийн жилд зарцуулах тосвийн зарлагын хэмжээг 56492799,6 тогрог, тосвийн хоронгоор хэрэгжvүлэх хоронго оруулалт, тоног тохооромж, их засварын зардлын дээд хэмжээг 4733075,1 тогрог, аймгийн орон нутгийн хогжлийн сангаас сумдын орон нутгийн хогжлийн санд олгох орлогын шилжvүлгийг 7099800,0 тогрог, аймгийн тосвоос сумдын тосовт олгох санхvүгийн дэмжлэгийг 12327362,9 тогрог, тусгай зориулалтын шилжvүлгээр санхvүжих зардлыг 34544902,1 тогрог аймгийн тосвоос орон нутгийн хогжлийн нэгдсэн санд товлорvүлэх хоронгийн хэмжээг 17600,0 тогрог байхаар тосовлон оруулжээ.

Тосвийг толовлохдоо орлого бүрдvүлэх боломжит эх vүсвэрvүдийг бүрэн дайчлах, эдийн засаг дахь татварын ачааллыг нэмэгдvүлэхгvүгээр тогтвортой орчинг бүрдvүлж, татварын хамрах хvүрээг орготгох, тосовт байгууллагуудын бvтэц, орон тоог

нэмэгдүүлэхгүй байх, урсгал зардлын осолтийг хязгаарлах, халамжийг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэгт нь чиглүүлэх, тосвийн вйл ажиллагааг ил тод нээлттэй байлгаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тодорхой бодлого хотолбор арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэх гэсэн гол зарчмуудыг мөрдлого болгосон хэмээн танилцуулж байв.

Аймгийн ИТХ-ын 2013 онд хэрэгжүүлэх вйл ажиллагааны тоолоогоог 93,9 хувьтай, Засаг даргын 2013 оны вйл ажиллагааны хотолборийг 37,6 хувьтай хэрэгжсэн хэмээн дүгнэжээ.

Энэ нь Засгийн газраас батлагдсан аргачиллын дагуу хийсэн үнэлгээ гэх боловч сорог хвчин болон зарим оролцогчдын зүгээс зарим зүйл дээр тухайлбал аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцсон аргачилал, зорилтот арга хэмжээнүүдийг дүгнэсэн дүгнэлт зэрэг нь зарим талаараа хуудуутай байна хэмээн шүүмжилж байсан. Ийм байдлаар аймгийн ИТХ-ын олонхийн бүлгээс аймгийн Засаг даргын вйл ажиллагааны хотолборийг хангалттай гэж дүгнэсэн бол цоонхийн бүлгээс хангалтгүй гэж үнэлсэн. Үнэлгээ огох гуравдагч этгээд гэж байхгүй болохоор хоёр этгээдийн эсрэг тэсрэг санал бүхий дүгнэлтийг олонхийн талынхаар нь авч баталгаажуулдаг жишгээр хангалттай хэмээн батлав.

Аймгийн ИТХ-ын ажлын үр дүн, Засаг даргын вйл ажиллагааны хотолборийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг тухайн байгууллагын бүрэлдэхүүнд, удирдлаганд нь ажилладаг аппаратын ажилтнууд гүйцэтгэдэг. Нэг үгээр хэлэхэд энэ нь оороо оорийнхоо ажилд дүн тавиад, олон нийтэд зарлаж байна гэсэн үг. Хуучин ч ийм байсан, одоо ч ийм байгаа. Оорчилж, засахыг хүсэхгүй байгаа манай торийн тогтолцооны нэг гажиг юм.

Хуралдааны үеэр толоологчид болон оролцогчдын зүгээс оргон хэрэглээний бараа, бензин шатахууны үнэ ханш оссон, үндэсний монгон тэмдэгтийн худалдан авах чадвар буурсан шалтгаан болон тогтворжуулах бололцоо нохцол нь ямар байгаа, бүсийн нэмэгдлийн асуудлыг УИХ-д тавьж шийдүүлэх боломжтой эсэх, Хошоотийн уурхайн ажил яагаад зогсонги байдалд орсон, цаашид хэрхэх толовтэй байгаа, “Чингис” бондын монго орон нутагт яагаад үр огоожоо огохгүй байгаа, суманд сум хогжүүлэх сангийн зориулалтаар олгогдох монгийг ард иргэдийн саналыг харгалзахгүйгээр тийм юманд зарцуул гэж шаарддаг нь ямар учиртай гэх мэтийг аймгийн Засаг даргаас асууж, хариулт авсан. Засаг дарга хариулахдаа шатахуун болон хэрэглээний барааны үнийн осолтийг буулгахын толоо ажиллана гэсэн ба бүсийн нэмэгдэл олгохыг ард түмэн зовшоорохгүй байгаа хэмээсэн нь ойлгомжгүй хариулт байв. Яагаад гэвэл баруун бүсийн ард иргэдийн дунд энэ асуудлаар ямар нэг санал асуулга явагдаагүй. Бүсийн ард иргэд

бүсийн нэмэгдэл бидэнд хэрэггүй гэж мэдэгдээгүй болохоор Засаг дарга ямар мэдээллийг үндэслэсэн нь тодорхойгүй юм. Хошоотийн уурхайг цаашид орон нутагт үр огоожоо огох бололцоотойгоор ажиллуулна гэсэн бодлого барьж байгаа мон “Чингис” бондын монго удахгүй орон нутагт тодорхой зүйлийг санхүүжүүлэх зориулалтаар орж ирэх байх гэсэн бол Засаг даргын хотолбор, зорилтыг нэр торлоор нь биелүүлэх зорилгоор сум хөгжүүлэх сангийн монгийг ч тийм юманд зарцуул гэж шаардаж болно. Би шаардах юмаа шаардана гэх утгатай хариулт огов.

Түүнчлэн Мах ноцлох зориулалтаар хоёр компанитай шууд гэрээ байгуулах үйл ажиллагаа шудрага бус явагдсан, баялаг бүтээж, аймгийн эдийн засгийн нохцлийг тогтвортой болгох зорилгоор зарцуулбал зохих нэлээд хэмжээний хоронго монгийг хот тохижилт нэрээр аар саар зүйлд үрж, үргүй зардал гаргаж байна, Сумдад хоронго санхүүг хувиарлахдаа хүн ам, газар нутгийн хэмжээ, алслалт, торийн үйлчилгээний цар хүрээ,багтаамжийг тооцолгүйгээр шудрага бус хувиарлалт хийж байна, аймгийн Засаг дарга албан ёсны сонгуульт ажилдаа ач холбогдол огохгүй, хүүхдийн толоо анхаарал хандуулахгүй байна, Хот тохижилтын газрын дэргэд торийн далбаан доор орон нутгийн омчит компани байгуулж, Хот тохижилтын газрын зарим омч хоронгийг тийшээ шилжүүлсэн, ажил үүргийг нь давхардуулсан, зэргээс хот тохижилтын үйл ажиллагааг явуулахад ойлгомжгүй байдал үүссэн гэх мэт санал, шүүмжлэлүүд гарч байв.

